



Засгийн хэлжээний
ийн улсын Нийдсэн санд
2021 оны 07 сарын 01-ны
дугаар 5341-рт бүртгэсэн

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 25 өдөр


Дугаар 147

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалт, Барилгын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.
3. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтийг ханггуулж, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах, журмын 4 дүгээр хавсралтаар батлагдсан үйлчилгээний хөлсний хэмжээг олон нийтэд мэдээлж, хяналт тавьж ажиллахыг төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй "Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-ын тэргүүн /М.Түмэнжаргал/, "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын ерөнхийлөгч /Д.Цэрэнжигмэд/ нарт даалгасугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Журам шинэчлэн батлах тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 217 дугаар тушаал, "Үйлчилгээний хөлс тогтоох тухай" Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 172 дугаар тушаал, мөн 2021 оны 109 дүгээр тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Б.МОНХБААТАР

151030475

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн
17 дугаар тушаалын хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ӨРГӨХ
БАЙГУУЛАМЖ, ТҮҮНИЙ ЭД АНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, УГСРАЛТ, ЗАСВАР
ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТОГТООХ, ТЭДГЭЭРТ ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилгын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн этгээдэд мөн хуулийн 4.1.21-д заасан зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, бүртгэх, хугацааг сунгах, нэмэлт ажлын төрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, мэдээлэлд өөрчлөлт оруулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, хяналт тавих үйл ажиллагааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ журмаар зохицуулна.

1.3. Энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан суурь нөхцөл шаардлагыг хангасан хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгоно.

1.4. Барилгын тухай хуулийн 20.2-т заасан барилга байгууламжийн зураг төсөл болон барилгын ажилд тусгай зөвшөөрлийг зөвхөн тухайн барилга байгууламжид олгоно.

1.5. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх эрхлэх тусгай зөвшөөрлийг Барилгын тухай хуулийн 33.1.15-д заасны дагуу барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр олгож, хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.

1.6. Хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох ажлыг Барилгын тухай хуулийн 34.1.14-т заасан чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа байгууллага /цаашид “зохион байгуулагч байгууллага” гэх/ нэг цэгийн үйлчилгээ болон цахим системээр зохион байгуулна.

1.7. Барилга байгууламжийн буулгалтын ажлыг тухайн барилгын ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд гүйцэтгэнэ.

1.8. Зохион байгуулагч байгууллага нь тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 9.1-д зааснаас гадна дор дурдсан зарчмыг баримтална. Үүнд:

- 1.8.1. тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байх;
- 1.8.2. тусгай зөвшөөрлийг барилга байгууламжийн төвөгшилтэй уялдуулан шатлан ахиулж олгох;
- 1.8.3. хариуцлага, туршлага, тогтвортой байдалд тулгуурлах.

Хоёр. Зохион байгуулагч байгууллагын чиг үүрэг

2.1. Зохион байгуулагч байгууллага тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын албатай байна. Ажлын алба нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 2.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах;
- 2.1.2. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэх;

2.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагатай байгуулсан гэрээний биелэлтийг хэлэлцүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутам танилцуулах;

2.1.4. тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нөхөн олгох;

2.1.5. тусгай зөвшөөрлийн хуулийн этгээдийн ерөнхий мэдээлэлд өөрчлөлт оруулах;

2.1.6. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлаар санал боловсруулах;

2.1.7. энэ журмын 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах.

Гурав. Өргөдлийн хүсэлт гаргах

3.1. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой хүсэлтээ зохион байгуулагч байгууллагад Барилгын салбарын мэргэжилтэн болон хуулийн этгээдийн мэдээллийн сангийн цахим систем (цаашид “тусгай зөвшөөрлийн цахим систем” гэх) www.license.mcis.gov.mn-ээр дамжуулан гаргана.

3.2. Хүсэлт гаргагч нь “ДАН” танилт нэвтрэлтийн нэгдсэн систем /цаашид “ДАН систем” гэх/-ийг ашиглан иргэний баталгаажуулалт хийсэний дараа төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем /цаашид “ХҮР систем” гэх/-ээр дамжин хуулийн этгээдийн бүртгэлийг үүсгэнэ. Хуулийн этгээд нь зөвхөн нэг бүртгэлтэй байна.

3.3. Хуулийн этгээдийн удирдах болон инженер техникийн ажилтнууд энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу ХҮР системээр дамжуулан дараах мэдээллийг баталгаажуулна. Үүнд:

3.3.1. хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээлэл;

3.3.2. иргэний үнэмлэхний мэдээлэл;

3.3.3. нийгмийн даатгалын мэдээлэл;

3.3.4. дээд боловсролын мэдээлэл.

3.4. Барилгын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн цахим системийн сургалтын мэдээллийн сангаас мэргэшсэн болон зөвлөх инженерийн мэдээллийг татаж цахим системд оруулна.

3.5. Хуулийн этгээд нь дараах мэдээллийг нэмж оруулна. Үүнд:

3.5.1. холбоо барих мэдээлэл;

3.5.2. систем хариуцсан ажилтны мэдээлэл;

3.5.3. Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй танилцуулга;

3.5.4. Гүйцэтгэсэн ажлын мэдээлэл;

3.5.5. Машин механизм, тоног төхөөрөмжийн мэдээлэл.

3.6. Хуулийн этгээд нь энэ журмын 6-р бүлэгт заасан холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүсэлтийг үүсгэж илгээнэ.

Дөрөв. Өргөдлийн хүсэлтийг хянаж, баталгаажуулах

4.1. Хуулийн этгээдээс илгээсэн хүсэлтийг зохион байгуулагч байгууллага хүлээн авч материалын иж бүрдэл болон_суурь нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаж, баталгаажуулна.

4.2. Хуулийн этгээд тусгай зөвшөөрлийг шинээр авах хүсэлт гаргасан тохиолдолд инженер техникийн ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг сүүлийн 1 сар, сунгах болон нэмэлтээр авах хүсэлт гаргасан тохиолдолд сүүлийн 3 сар тасралтгүй төлсөн байна.

4.3. Суурь нөхцөл, шаардлагад заасан мэргэшлийн зөвлөх зэрэгтэй инженер нь тусгай зөвшөөрөлтэй 3 хүртэлх хуулийн этгээдэд ажиллаж болох ба гэрээг мэдээллийн санд бүртгүүлсэн байна.

4.4. Тусгай зөвшөөрөл сунгах хүсэлтийг тухайн тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногоос багагүй хугацаанд гаргана.

Тав. Өргөдлийн хүсэлтийг шийдвэрлэх

5.1. Зохион байгуулагч байгууллага нь хуулийн этгээдийн хүсэлтийг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авснаас хойш 5 өдрийн дотор (7 хоног бүрийн Пүрэв гарагийн 15.00 цагаар тасалбар болгон) нэгтгэж, баталгаажуулан барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад илгээнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан баталгаажуулалтыг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох шийдвэрийг ажлын 5 хоногийн дотор гаргана.

5.3. Цахим программ тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол энэ тухай үндэслэлийг тодорхой зааж өргөдөл гаргагчийн цахим системд нь мэдэгдэл илгээнэ.

5.4. Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээдийн бүрдүүлсэн баримт бичиг болон бусад мэдээллийн өргөдөл шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

5.5. БМУТЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулагч байгууллага нь хуулийн этгээдийн мэдээллийн үнэн зөв байдлыг урьдчилан танилцаж, ажлын албанд танилцуулна. /Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд хамаарна/

Зургаа. Цахим системд оруулах мэдээлэлд тавих шаардлага болон бүрдүүлэх баримт бичиг

6.1 Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл /БУАТЗ/ авах хуулийн этгээд нь мэдээллийн сангийн цахим системд бүртгүүлэн зохих журмын дагуу хүсэлтээ шийдвэрлүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.1.1 БУАТЗ сунгах болон барилгын үйл ажиллагаагаа өргөтгөж, нэмэлт ажлын төрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан хувь хэмжээгээр норм, нормативын санд төлөх шимтгэлийн дүнг оруулах, шимтгэл төлсөн баримтыг хавсаргах

6.1.2 БУАТЗ олгогчтой байгуулсан гэрээ дүгнэсэн тэмдэглэл;

6.2 Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл сунгах, нэмэлт ажлын төрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ журмын 6.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

6.2.1 магадлал хийлгэсэн зураг төслийн ажлын мэдээллийг зураг төсөл, магадлалын системээс баталгаажуулна ./бүтээлийн нэр, огноо, магадлалын ерөнхий дүгнэлтийн дугаар/.

6.3 Барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл /БМУТЗ/ авах хуулийн этгээд нь зохион байгууллагын нэг цэгийн үйлчилгээ болон мэдээллийн сангийн цахим системд бүртгүүлэн зохих журмын дагуу хүсэлтээ шийдвэрлүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна Үүнд:

- 6.3.1 БМУТЗ сунгах, нэмэлт ажлын төрөл болон шинээр авах хүсэлт гаргасан хуулийн этгээдийн бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ;
- 6.3.2 Бүтээгдэхүүнд хийлгэсэн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг;
- 6.3.3 БМУТЗ шинээр авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь өөрийн өмчлөлд байгаа зориулалтын технологийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, анхан шатны лабораторийн багаж хэрэгсэл машин механизмын жагсаалт;
- 6.3.4 Үйлдвэрлэсэн барилгын материал, бүтээгдэхүүнийхээ чанарын үндсэн үзүүлэлтийг тодорхойлох лабораторитой байх;
- 6.3.5 БМУТЗ сунгах, үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа өргөтгөх, хүчин чадал болон бүтээгдэхүүний нэр төрөлд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор нэмэлт ажлын төрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь хийсэн ажлын тайлан, БМУТЗ олгогчтой байгуулсан гэрээ дүгнэсэн тэмдэглэл.

6.4. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тухайлсан объектын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна Үүнд:

- 6.4.1. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зурагт хийсэн магадлалын ерөнхий дүгнэлт, өндөр барилгын мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл;
- 6.4.2. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байх;

6.5. Онцгой төвөгшилтэй болон Барилгын тухай хуулийн 20.2-д заасан барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авах, сунгах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь энэ журмын 4.1.-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 6.5.1.Онцгой төвөгшилтэй барилгын ажлыг хийж гүйцэтгэхэд тухайн төслийн зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлтийн тухай мэдээлэл /Огноо, дугаар/;
- 6.5.2.Өндөр төвөгшилтэй барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх;
- 6.5.3.Барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг төсөл болон барилгын үйлдвэрлэл, зохион байгуулалт, технологийн мэргэжлийн зөвлөлийн хурлын тэмдэглэл.

6.6. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тухайлсан объектын тусгай зөвшөөрөл нь зөвхөн тухайн объектод хамаарах бөгөөд уг объектыг баригдаж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

6.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээг гээсэн, үрэгдүүлсэн шалтгаанаар нөхөн олгуулах хүсэлт гаргасан бол дор дурдсан баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:

- 6.7.1. албан хүсэлт;

- 6.7.2. гэрчилгээг гээсэн тухай өдөр тутмын сонинд зарлуулсан хуулбар;
6.7.3. Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан хувь хэмжээгээр норм, нормативын санд шимтгэл төлсөн баримт.

6.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээдийн оноосон нэр, эзэмшигчийн нэр өөрчлөгдсөн шалтгаанаар тусгай зөвшөөрлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан бол дор дурдсан баримт бичгийг үндэслэн олгоно. Үүнд:

- 6.8.1. Улсын бүртгэлийн газрын лавлагаа;
6.8.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
6.8.3. хуулийн этгээдийн дүрмийн хуулбар;
6.8.4. эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн гэрчилгээний эх хувь.

6.9. Гадаадын хуулийн этгээд нь БУАТЗ авах хүсэлт гаргахдаа энэ журмын 6.1-6.6-д заасан хамаарах баримт бичиг бүрдүүлэхээс гадна тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон БУАТЗ-ийн гэрчилгээний хуулбар, баталгаат орчуулгын эх хувийг хавсаргана. Мөн Барилгын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3-д заасны дагуу барилгын үйл ажиллагааг Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран гэрээ байгуулж; эрхэлнэ.

6.10. Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан хуулийн этгээд нь Барилгын тухай хуулийн 34.1.14-д заасны дагуу нэг цэгийн үйлчилгээгээр үйлчилгүүлэх үйлчилгээний хэлс болон улсын тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хэмжээгээр төлнө.

6.11. Энэ журмын 6.10-д заасан үйлчилгээний хэлсний хэмжээг энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу тогтоох бөгөөд нэг цэгийн үйлчилгээгээр үйлчилгээ авснаас хойш 30 хоногийн дотор хүчинтэй байна.

6.12. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан хуулийн этгээдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь мэргэжлийн инженер, техникийн ажилтан байна. Мөн хос мэргэжилтэй инженер техникийн ажилтан нь тухайн хуулийн этгээдэд өөрийн эзэмшсэн хос мэргэжил тус бүрээр бүртгэгдэх боломжтой байна.

Долоо. Хуулийн этгээдэд тавигдах шаардлага

7.1. БУАТЗ эрхлэх хүсэлт гаргасан /барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх/ хуулийн этгээдэд Барилгын тухай хуулийн 10.1-д заасан ангиллын дагуу барилга байгууламжийн төвөгшлөөр, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдэд үйлдвэрлэлийн төрлөөр, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдэд өргөх байгууламжийн төрлөөр энэ журмын 1 дүгээр хавсралтад зааснаар тогтооно.

7.2. Мэдээллийн санд бүртгэлтэй инженер, техникийн ажилтан нь мэдээллийн санд баталгаажсанаас хойш 90 хоногийн дотор шилжилт, хөдөлгөөн хийхгүй бөгөөд шилжилт, хөдөлгөөн хийсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь суурь нөхцөл шаардлагад заасан инженер, техникийн ажилтныг 30 хоногийн дотор нөхж бүртгүүлнэ.

7.3. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл шинээр авах хүсэлт гаргасан хуулийн этгээдэд бага төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл олгоно.

7.4. Дунд төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь бага төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэй 1-ээс доошгүй жил үйл ажиллагаа явуулж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнасан байна.

7.5. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь дунд төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөлтэйгөөр 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулж, хийж гүйцэтгэсэн ажлаа тайлагнасан байна.

7.6. Онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт гаргасан хуулийн этгээд нь өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна.

Найм. Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

8.1. Тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу 5 хүртэл жилээр олгож, мөн хугацаагаар сунгах, нэмэлт ажлын төрлийг тухайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаагаар олгоно.

8.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь энэ журмын 3 дугаар хавсралтаар батлагдсан гэрчилгээний загвараар үнэт цаасан дээр хэвлэгдэх бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4.1-д заасан мэдээлэл болон бусад мэдээллийг тусгана.

8.3. Тусгай зөвшөөрөлтэй эсэх талаарх лавлагааг төрийн үйлчилгээний цахим системээс QR кодоор баталгаажсан нууцлалтай авч болно.

8.4. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн энэ журмын 2 дугаар хавсралтаар батлагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдтэй байгуулах гэрээний загварын дагуу зохион байгуулагч байгууллага гэрээг байгуулж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгох, хяналт тавих үйл ажиллагааг шуурхай зохион байгуулна.

Ес. Хэрэгжилтийн явцад хяналт тавих, хариуцлага

9.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно. Мөн Барилгын тухай хуулийн 20.8-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, дүгнэлт гаргуулах асуудлаар барилгын улсын хяналт хэрэгжүүлэх байгууллага болон барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.

9.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болсноос хойш ажлын 3 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд болон харьяалах татварын алба, нийгмийн даатгалын байгууллагад албан бичгээр болон цахимаар мэдэгдэнэ.

9.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь барилгын салбарын статистик мэдээ, үйл ажиллагааны тайлангаа 1 жилээс дээш хугацаанд мэдээллийн санд ирүүлээгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

9.4. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан хуулийн этгээд нь шийдвэр гарснаас хойш 1 жилийн дотор тусгай зөвшөөрөл эзэмших гэрээ байгуулаагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэлх арга хэмжээг авна.

9.5. Хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, бусдын бичиг баримтыг зөвшөөрөлгүйгээр ашигласан тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох хүсэлтээс татгалзаж хар жагсаалтад оруулж нийтэд мэдээлнэ.

9.6. Тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

9.7. Энэ журмын 9.6-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож тухайн байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлнэ.

Арав. Баримт бичгийг баяжуулах, хадгалах

10.1. Зохион байгууллагч байгууллага нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн талаарх мэдээллийг шинэчлэх, баяжуулах, холбогдох өөрчлөлтийг хийх, мэдээллийн сангийн тасралтгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, мэдээллийн үнэн зөвийг хариуцаж, байгууллага, иргэдийг мэдээллээр ил тод хангаж ажиллана.

10.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавих, дүгнэх, тайлан мэдээ гаргах, мэдээллийн сангийн бүрдүүлэлт хийж тэдгээрийн үр дүнг Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах, мэдээллээр хангах ажлыг зохион байгууллагч байгууллага хариуцна.

10.3. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг Барилгын тухай хуулийн 34.1.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллага, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн инженер, техникийн ажилтны шилжилт хөдөлгөөнийг барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж буй байгууллагууд тус тус гүйцэтгэнэ.

10.4. Долоо хоног бүрийн ажлын албаны баталгаажуулсан тэмдэглэлийг тусгай зөвшөөрлийн тушаал бүрийн эх хувьд хавсаргаж барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим архивд хадгална.

Арван нэг. Бусад

11.1. Тусгай зөвшөөрлийг олгохтой холбогдон иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 17.1-д заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлнэ.

----- oOo -----